



АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ ХУРАЛДАА.

2016 оны 01-р сарын 08-ны өдрийн хурлаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталлаа. Мөн Засаг даргын зөвлөлөөс ирүүлсэн саналыг авч хэлэлцээд төр нийгэмдээ олон жил идэвх зүтгэл гарган ажиллаж, хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан нэр бүхий иргэдийг Төрийн дээд одон медалиар шагнуулахаар Ерөнхийлөгчийн тамгын газарт уламжиллаа.

2016.01.29-ны өдрийн тэргүүлэгчдийн хурлаар дараах 3 асуудлыг авч хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын сонгуулийн тойрог тогтоох тухай
2. Орон нутгийн өмчийн тухай /Худалдах, актлах, балансаас балансад шилжүүлэх зарим эд хөрөнгө/
3. Шагналд тодорхойлох тухай

СУМДЫН ИТХ-ЫН ДАРГА, ЗАСАГ ДАРГА НАРЫН НЭГДСЭН СУРГАЛТ БОЛЛОО.

2016 оны 01-р сарын 11-нд Сумдын ИТХ, Засаг дарга нарын нэгдсэн сургалт, цугларалт боллоо. Уг сургалтын зорилго нь Аймгийн 2015 оны зорилтын хэрэгжилт, 2016 онд дэвшүүлсэн зорилт, цаг үеийн ажлаар зөвлөмж, үүрэг чиглэл өгөх юм.

Сургалтаар: Аймгийн ИТХ-ын дарга нарт дараах чиглэлээр мэдээлэл өгч, цаашид авч хэрэгжүүлэх ажлын зөвлөмж, зөвлөгөө өгөв. Үүнд:

1. 2015 оны ажлын тайлагналт, үр дүн
2. Нийтийн сонголын тухай хууль
3. 2016 оны өмчийн тооллого
4. ХАСХОМ бүртгэл хяналт



ҮНДСЭН ХУУЛЬ БАТЛАЛЦСАН АХМАД БУУРЛУУДДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ.

Өнөөдөр шинэ Үндсэн хууль батлагдсаны 24 жилийн ой тохиож байгаа билээ.

БНМАУ-н Ардын Их Хурлын 12 дахь удаагийн сонгуулийн II хуралдаан нийт 76 хоног хуралдаж 1992 оны 01-р сарын 13-ны өдөр баталсан бөгөөд манай аймгаас Дархан аварга, хөдөлмөрийн баатар Х.Баянмөнх, Хөдөлмөрийн баатар Б.Жанцансамбуу тэргүүтэй 21 хүн оролцож байжээ.



Энэ өдрийг тохиолдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ч.Чимэд орон нутагтаа аж төрөн амьдарч байгаа Хөдөлмөрийн баатар Б.Жанцансамбуу нарыг хүлээн авч уулзан, хүндэтгэл үзүүллээ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН УДИРДАХ АЖИЛТНЫ УУЛЗАЛТ, ЗӨВЛӨГӨӨН БОЛЛОО.

Энэ сарын 14-ны өдөр “Ойрад” ХДТ-т “Эрүүл мэндийн салбарын шинэчлэлд бидний оролцоо” нэртэй аймгийн эрүүл мэндийн удирдах ажилтнуудын уулзалт зөвлөгөөн боллоо.

Зөвлөгөөнийг аймгийн ИТХ, ЗДТГ, ЭМГ-аас хамтран зохион байгуулж байгаа бөгөөд Увс аймгийн 19 сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч, багийн эмч, аймгийн өрхийн эмнэлэгийн эрхлэгч эмч нар, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын удирдлага болон аймгийн ЭМГ, Нэгдсэн эмнэлэгийн удирдлагууд зэрэг 110 гаруй хүний бүрэлдэхүүнтэй томоохон хэмжээний уулзалт, зөвлөгөөн болсон юм. Аймгийн ИТХ нь 2012-2016 оны бүрэн эрхийн хугацаанд Аймгийн Засаг даргын 2012-2016 оны мөрийн хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх зорилтын “Эрүүл чийрэг Монгол хүн” хөтөлбөрт 47 ажлыг хийхээр тусгаж, эрүүл мэндийн салбарт аймгийн ОНХС-аас 703,7 сая төгрөгийг 22 арга хэмжээнд, эрүүл мэндийн төсөл хөтөлбөрт 150 сая төг-ийг зарцуулан ажилласан байна. Үүнээс: Диализийн аппаратын ус нэрэгч, шүүгч аппарат, эмэгтэйчүүдийн хэвлийн хөндийн дурангийн хөндийн хагалгааны багаж худалдан авахад ОНХС-аас 117 сая төгрөгийг тусган тендер зарласан боловч ямар нэгэн компани санал ирүүлээгүй тул биелээгүй байна.



“ХАМТЫН ХҮЧ-НУТГИЙН ХӨГЖИЛ” ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН ЭХЭЛЛЭЭ.

2016.01.27-ны өдөр төрийн ордонь их танхимд УИХ-ын тамгын газар, ЗГ-ын хэрэг эрхлэх газар, Монголын баг сумдын үндэсний холбоо ТББ-ын хамтран зохион байгуулж байгаа “ХАМТЫН ХҮЧ-НУТГИЙН ХӨГЖИЛ” үндэсний чуулган боллоо.



Чуулганд Монгол улсын 330 сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Нийслэлийн 9 дүүргийн 152 хорооны засаг дарга, 21-н аймгийн тэргүүний 100-н багийн Засаг дарга, нутгийн хөгжлийн 78-н манлайлагчид оролцож байгаа бөгөөд манай аймгаас 16 сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нар оролцож байна. Чуулганы зорилго нь Иргэдийн хамтран ажиллах, нийтээрээ хөгжих санаачилгыг дэмжих юм.

Чуулганаар нутгийн удирдлага, хөгжлийн эрх зүйн орчинг сайжруулах тухай, хамтын хүчний давуу талыг бэхжүүлэх гарц, боломжууд болон зарим сумдын сайн турширгуудын талаар илтгэл, танилцуулга, чөлөөт ярилцлага хийгдэх юм.



БӨХМӨРӨН СУМ

Сумын ИТХ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Бөхмөрөн сумын БОТХ-ийн тасагтай хамтран



хяналт шалгалтыг 2016 оны 01 сарын 10 -11-ний өдөрүүдэд Ачит нуур орчмын газруудад хийлээ. Хяналт шалгалт хийх үед Баянөлгий аймгийн 4 машинтай 20 гаруй иргэн хууль бусаар зөвшөөрөлгүй загас агнаж байсныг зосоон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд арга хэмжээ авлаа. Энэ үеэр Бөхмөрөн сумын нутагт отороор өвөлжиж байгаа өөрийн сумын 10 гаруй өрхийг эргэх ажлыг хийлээ. Мөн хяналт шалгалтын хүрээнд Ачит багийн нутагт орших Хөөтийн уурхайгаас гар аргаар нүүрс олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зогсоож багийн Засаг дарга, ИНХ-ын дарга нарт байгаль орчны улсын байцаагчийн албан шаардлагыг хүлээлгэн өгч ажиллалаа.

САГИЛ СУМ:

Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар сумын ИТХ-аас 2016 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө болон багийн ИНХ-уудыг зохион байгуулах хуваариарыг хэлэлцэн баталлаа. ГХУСА-ын төлөвлөгөөнд тусгагдсан “Архигүй Монгол” аяны хүрээнд сумын МХТ-тай хамтран согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх цэгүүдэд дэлгүүрийн стандарт хангалтанд хяналт хийх ажлын хэсгийг байгуулсан.

“Архигүй цагаан сар” уриалгыг иргэд дунд сурталчлав. Цаг үе өвөлжилт хүндэрч байгаа учраас аймгаас ОБГазраас өвс тэжээлийн хангалтын арга хэмжээнд оролцож,

малчдын хүндэрсэн зарим хот айлуудад өвс тэжээл хүргэх ажлыг

зохион байгуулав. Цаг үе өвөлжилт хүндэрч байгаа учраас аймгаас ОБГазраас өвс тэжээлийн хангалтын арга хэмжээнд оролцож, малчдын хүндэрсэн зарим хот айлуудад өвс тэжээл хүргэх ажлыг зохион байгуулав.



ДАВСТ СУМ:

Хөдөөгийн багийн малчдын өвөлжилтийн байдалтай явж танилцлаа. Мөн 1-р сарын 21-26-ны хооронд Хурлын дарга, Засаг дарга нар хамтран явж, манай суманд хуваарилагдсан нийт 60 тн өвс, 30 тн тэжээлийг малчдад хүргүүлэх ажлыг зохион байгуулав. Мөн ОНХ-н сангийн хөрөнгөнөөс өвс, тэжээлийг

нэмж авч, малчдад хүргүүлэв.

Хүйтний эрч чангарч, цас их орж малын өвс тэжээл

дутагдсанаас өнөөдрийн байдлаар 3587 толгой мал хорогдсон мэдээлэлтэй байна.



ӨЛГИЙ СУМ:

Өлгий сумын ИТХ нь нэгдүгээр сарын тэргүүлэгчдийн хурлаар сумын ИТХ-ын 2016 оны ажлын төлөвлөө,



болон сумын сонгуулийн тойргийг баталлаа. Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэн чиглэлээр сумын цагдаагийн хэсгээс ЗДТГ болон Ахлах сургуулийн сурагчдад хуулийн талаарх мэдээлэл хүргэж ажиллалаа.

МАЛЧИН СУМ:

Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар

1. Сумын ГХУСАЗСЗ-өөс 2016 онд хийж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталлаа.
2. Хяналт шалгалтын чиглэлээр 2016 онд хийх ажлын төлөвлөгөөг баталлаа.

Мөн сумын төвийн бүх өрхөөр ЗДТГ-ын албан хаагчдыг хуваарилан явж ажиллууллаа. Энэ үеэр сум, аймгаас зохиож буй ажил, ИТХ-ын хурлын хуралдааны ишийдвэр, сум хөгжүүлэх НЭЗ-ийн зорилтын биелэлтийг сурталчлахаас гадна сар шинийн баярыг угтаж хийх цэвэрлэгээ, тохижилт, архигүй цагаан сар тэмдэглэх хөдөлгөөн өрнүүлж байгаа талаар сурталчилгаа хийж өрхийн дэвтэрийн хөтлөлт хийх зэрэг ажлуудыг өрнүүллээ.

Хаяг

Увс аймаг, Улаангом хот, 3-р баг Ө.Бадрахын гудамж, ЗДТГ-ын байр 210тотом

Утас :70453627

Факс :70452214

И Мэйл:

info@khural.uv.gov.mn

Вэб сайт:

http://uvs.khural.mn/

Facebook:

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал